



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/1025

Улаанбаатар хот

Угаарын хийн хордлогоос
урьдчилан сэргийлэх, эрсдэлээс
хамгаалах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 62 дугаар, 2022 оны 223 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

1.1.нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд жил бүрийн хавар намрын улиралд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах арга хэмжээг нутаг дэвсгэртээ зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга нарт;

1.2.сайжруулсан түлшний нөөцлөлт, тээвэрлэлтийн үеийн хадгалалтын горим, чанар, стандартыг хангаж, стандартын шаардлага хангаагүй зуухтай айл өрхийн судалгааг гарган, зуухны битүүмжийг шалгах, зөв галлагааны зөвлөмж болон угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн ажиллагааны зааварчилгаа өгөх, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг “Таван толгой түлш” ХХК (Ц.Даваацэрэн)-д;

1.3.угаарын хийн хордлогын дуудлага мэдээллийг бүртгэлжүүлж, иргэдэд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, анхны тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар зөвлөмж, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж)-т;

1.4.угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой зөвлөмж, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулж, холбогдох санхүүжилтийг Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаас гаргахыг Нийслэлийн сургалт, судалгаа, олон нийттэй харилцах газар (Г.Хонгорзул)-т, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Ц.Ганболд)-т;

1.5.Зах, худалдааны төвүүдэд худалдаалагдаж байгаа ахуйн хэрэглээний зуухны стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Б.Батшагай)-т;

2.Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотойгоор холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулсан шуурхай штабын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөөд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2022 оны
08 дугаар сарын 07-ний өдрийн
А/1025 дугаар захирамжийн
хавсралт



ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар,
ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын
асуудал хариуцсан орлогч

Гишүүд: Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга;
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын
дарга;

“Тавантолгой түлш” ХХК-ийн захирал;

Экологийн цагдаагийн албаны дарга;

Нийслэлийн Онцгой байдлын газрын
Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн
Нийслэлийн онцгой комиссын нарийн бичгийн
дарга;

Баянгол дүүргийн Засаг дарга;

Баянзүрх дүүргийн Засаг дарга;

Налайх дүүргийн Засаг дарга;

Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга;

Сүхбаатар дүүргийн Засаг дарга;

Хан-Уул дүүргийн Засаг дарга;

Чингэлтэй дүүргийн Засаг дарга.

Нарийн бичгийн
дарга:

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой
тэмцэх газрын дарга

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ОРЧНЫ
БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГА Ц.ГАНБОЛД

УГААРЫН ХИЙН ХОРДЛОГООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТУХАЙ АЖЛЫН УДИРДАМЖ

2022 оны 08 дугаар сарын 23

Улаанбаатар хот

Нэг. Зорилго

1.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62, 2022 оны 223 дугаар тогтоолыг тус тус үндэслэн угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээний тухай ажлыг зохион байгуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Нийслэлийн төвийн 6 дүүрэг, Налайх дүүргийн гэр хорооллын айл өрхүүд хамрагдана.

Гурав. Хэрэгжүүлэх хугацаа

3.1. 2022 оны 08 дугаар сарын 25 -ны өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хэрэгжүүлэх байгууллагууд

4.1. Удирдамжийн дагуу 7 дүүргийн гэр хорооллын хороодод угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох байгууллагууд зохион байгуулж, дүүргийн Засаг дарга нар хариуцан ажиллана.

Тав. Зохион байгуулалтын үйл ажиллагаа

5.1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд жил бүрийн хавар намрын улиралд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах арга хэмжээг нутаг дэвсгэртээ зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга нар зохион байгуулж, ажиллана.

5.2. Сайжруулсан түлшний нөөцлөлт, тээвэрлэлтийн үеийн хадгалалтын горим, чанар, стандартыг хангаж, стандартын шаардлага хангаагүй зуухтай айл өрхийн судалгааг гарган, зуухны битүүмжийг шалгах, зөв галлагааны зөвлөмж болон угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн ажиллагааны зааварчилгаа өгөх, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг "Таван Толгой Түлш" ХХК зохион байгуулж, ажиллана.

5.3. Угаарын хийн хордлогын дуудлага мэдээллийг бүртгэлжүүлж, иргэдэд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, анхны тусламж үйлчилгээ үзүүлэх талаар зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар зохион байгуулж, ажиллана.

5.4. Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой зөвлөмж мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, сурталчилах ажлыг тогтмол зохион байгуулж холбогдох санхүүжилтийг байгууллагын Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаас гаргахыг Нийслэлийн сургалт, судалгаа олон нийттэй харилцах газар, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар тус тус хариуцан ажиллана.

5.5. Зах, худалдааны төвүүдэд худалдаалагдаж байгаа ахуйн хэрэглээний зуухны стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Экологийн цагдаагийн алба тус тус зохион байгуулж, ажиллана.

5.6. Нийслэлийн Онцгой байдлын газрын салбар нэгжийн хэмжээнд ажиллах машин механизм, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж "Угаарын хийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж"-ийг зарлан мэдээлэх, угаарын хийн хордлогод өртөх эрсдэлтэй айл өрхөөр биечлэн очиж ажиллахыг шуурхай зохион байгуулна.

5.7. Нийслэлийн төвийн 6 дүүрэг, Налайх дүүргийн Хог тээвэрлэгч байгууллагуудын машин механизм, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж "Угаарын хийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж"-ийг зарлан мэдээлэх ажлыг шуурхай зохион байгуулна.

5.8. Гэр хорооллын айл өрхүүдийг түлшний галлагаанаас үүдэлтэй угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх зөвлөмжийг шуурхай хэвлүүлж, өрх бүрт хүргэх арга хэмжээг зохион байгуулна.

5.9. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг зөвлөмжийг иргэд, олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажил зохион байгуулна.

5.10. Шаардагдах санхүүжилтийг "Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаас гаргаж, тайланг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар 14 хоног бүр Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газарт хүргүүлнэ.

Зургаа. үр дүн

6.1. Удирдамжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нэгтгэн 14 хоног бүр Нийслэлийн ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлыг бууруулах асуудал хариуцсан орлогчид тайлагнана.



НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээг зохион байгуулах "Ажлын хэсэг"-ийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ц.Цолмон	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
	Г.Даваажаргал	Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтсийн дарга
	Э.Цогзолмаа	Байгальд ээлтэй технологи, сэргээгдэх эрчим хүч хариуцсан мэргэжилтэн
	Д.Сэлэнгэ	Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
	Ж.Балжинням	Үйл ажиллагааны менежер
	Г.Энхжаргал	Түлшний техникийн шинжилгээ хариуцсан ажилтан
Нарийн бичгийн дарга	Г.Бат-Оюун	Хэсэгчилсэн дулаан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэг (Ц.Цолмон)-д даалгасугай.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНБОЛД

Ажлын хэсэг 2022
1150500132



НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээг зохион байгуулах "Ажлын хэсэг"-ийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ц.Цолмон	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
	Г.Даваажаргал	Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтсийн дарга
	Э.Цогзолмаа	Байгальд ээлтэй технологи, сэргээгдэх эрчим хүч хариуцсан мэргэжилтэн
	Д.Сэлэнгэ	Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
	Ж.Балжинням	Үйл ажиллагааны менежер
	Г.Энхжаргал	Түлшний техникийн шинжилгээ хариуцсан ажилтан
Нарийн бичгийн дарга	Г.Бат-Оюун	Хэсэгчилсэн дулаан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэг (Ц.Цолмон)-д даалгасугай.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНБОЛ

Ажлын хэсэг 2022/
1150500132

ИЗЛТГ - Засаг тив

98019807

3253.81



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ
ТЭМЦЭХ ГАЗАР**

Наадамчдын зам 1200, Арцатын ам, 4 дүгээр хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас/Факс: (976-11) 31 48 76
Цахим шуудан : info@aprd.ub.gov.mn
Цахим хуудас: www.aprd.ub.gov.mn

2022.08.30 № 1/447
танай _____ -ны № _____ -т

Г НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН Г
ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Ү.ГАНБОЛД ТАНАА

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээний тухай” А/1025 дугаар захирамжаар Иргэдийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах хүрээнд холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулсан шуурхай штабын бүрэлдэхүүнийг байгуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгосон.

Иймд Нийслэлийн Хангарди ордонд Шуурхай штабын бүрэлдэхүүнийг ажиллуулах өрөө, тасалгаагаар хангаж хамтран ажиллахыг Танаас хүсье.

10 гар.